



**“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 1/09

Улаанбаатар хот



Хөрөнгө бүртгэх тухай





Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”- д заасны дагуу нийт 8,679,010,384 (найман тэрбум зургаан зуун далан есөн сая арван мянга гурван зуун наян дөрөв) төгрөгийн гүйцэтгэлийн дүн бүхий Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркаас Налайх-Чойрын чиглэлийн авто замтай холбох 4,64 км авто замыг байгууллагын хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө хүлээлцсэн акт болон балансад авсан шийдвэрийн хуулбарыг Өмчийн харилцааны газарт хүргүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Г.Ганцэцэг)-д даалгасугай.

ДАРГА

С.БАТЖАРГАЛ